

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№20/524

ШУС, НУС

2019

ФЭЙСБҮҮК СҮЛЖЭЭНД МОНГОЛ ХЭЛ ДЭЭР ТАРХСАН ХУУРАМЧ МЭДЭЭНИЙ  
СУДАЛГАА

Я.Борчулуун\*, Д.Идэржаргал\*\*

\* АНУ-ын Норфэстэрнийн Их сургуулийн Дата аналитикс хөтөлбөрийн судлаач, доктор (Ph.D)

\*\* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үгс:** үнэний дараах эрин, нийгмийн сүлжээ сайтууд, фэйсбүүк, хуурамч мэдээ, хэвлэл мэдээллийн боловсрол

**Д**элхийн олон орны адил Монгол Улс ч сошиал медиагийн нөлөөгөөр үнэний дараах эринд шилжлээ. Хуурамч мэдээлэл тархах үзэгдэл гаарч, гүтгэлэг, доромжлол хувь хүмүүс хийгээд байгууллагууд, нийгмийн бүлгүүдийг хохироож, олон нийтийн санаа бодолд нөлөөлөл чухал хүчин зүйл боллоо. Энэ үзэгдэл сэтгүүл зүйн салбар хийгээд олон нийтийн хэвлэл мэдээллийн боловсролыг сорьж, тэдний сонголт шийдвэрт нөлөөлж байна. Харин Монголын нийгмийн сүлжээн дэх хуурамч мэдээний үр нөлөөг өргөн хүрээнд судалсан тохиолдол үгүй бөгөөд төр засгаас үүнтэй тэмцэх нь удаан байна.

Энэхүү судалгааны ажил нь Монголын фэйсбүүк сүлжээгээр тархаж буй хуурамч мэдээллүүдэд анализ хийж, үр нөлөөг тодруулахыг зорив. Гурван сарын хугацаанд тус сүлжээгээр тархсан хуурамч мэдээллүүдийг цуглуулж, хуурамч болохыг баталгаажуулав. 200 орчим хуурамч мэдээний

сэдэв агуулга, хэлбэр, түгээгдсэн байдалд шинжлэв. Мөн тэдгээр хуурамч мэдээллүүд нь нийгэм цаг үеийн асуудлуудтай хэрхэн холбогдож байна, ямар зорилгоор түгээгдэж байна, олон нийт түүнийг хэрхэн хүлээж авч байна, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ талаар хэрхэн мэдээлэв зэрэг асуудлуудад хариулж, үр нөлөөг тодруулахыг оролдлоо.

**1. Хуурамч мэдээ (fake news) хэмээх нэр томъёоны тухайд.**

Оксфордын толь бичиг “post-truth age” (үнэний дараах эрин) хэмээх нэр томъёог 2016 оны үгээр тодруулсан бөгөөд “олон нийтийн санаа бодлыг бүрэлдүүлэхэд баримт нь хувийн бодол, сэтгэл хөдлөлөөс бага нөлөөтэй байх орчин нөхцөл”<sup>1</sup> хэмээн тодорхойлжээ. Ийм нийгэм бий болсны гол шалтгааныг судлаачид сошиал медиа, тэр дундаа хамгийн алдартай нь болох Фэйсбүүк, Твиттер тэдгээрээр тархаж буй хуурамч мэдээ (fake news)-тэй холбон тайлбарлаж байна<sup>2</sup>. Хүмүүсийн санаа бодол, сонголтод нөлөөлж, үнэний дараах эринг бий болгож буй хуурамч мэдээ гэж юу вэ? Үүнийг хэрхэн тодорхойлох вэ?

Одоогоор монгол хэл дээр fake news-ийг албан ёсоор орчуулж буулгасан зүйл үгүй. Тиймээс энэ талаар бичигчид хуурамч мэдээ, худал хуурмаг мэдээлэл хэмээн монгол хэлнээ буулгаж байна. “Хуурамч мэдээ” (fake news) хэмээх нэр томъёог үгийн утгыг нь үндэслэн тодорхойлбол тэдгээр мэдээний түүхүүд нь худал хуурмаг буюу түүх өөрөө зохиомол, баримт сэлт, эх сурвалжгүй гэсэн санааг илтгэнэ. Гэвч хуурамч мэдээ нь ингэж явцуугаар тодорхойлж боломжгүй өргөн утга санааг агуулж байна. Энэ нь түүнийг бий болгосон зорилгоос шалтгаалж байдаг. Тухайлбал, зарим хуурамч мэдээ хүлээн авагчдыг төөрөгдүүлэх зорилготой ухуулга сурталчилгаа байж болно. Зарим нь эдийн засгийн зорилготой буюу уншсан хандалтын тоогоор ашиг орлого нэмж байдаг кликбэйт (clickbait) байж болно. Харин зарим нь санамсаргүй гаргасан алдаанаас үүссэн хуурамч мэдээ байж ч мэднэ.

Зарим хуурамч мэдээ үнэний ортой боловч түүнийг батлах баримт, эх сурвалжгүй байдаг бол зарим нь баримттай боловч зөвхөн нэг талыг барьсан, өдөөн хатгасан шинжтэй байж болно. Тэгэхээр хуурамч мэдээ нь ташаа мэдээллээс биш мэдээлэл хүртэлх (from mis- to dis-information) өргөн ойлголтыг хамарч байна<sup>3</sup>. Ташаа мэдээлэл (misinformation)<sup>4</sup> гэдэг нь санамсаргүйгээр үүсгэгдэж, түгээгдсэн буюу мэхлэх зорилго агуулаагүй худал ташаа мэдээлэл юм. Харин биш мэдээлэл (disinformation)<sup>5</sup> нь үнэнийг бүрхэгдүүлэх, олон нийтийн санаа бодолд нөлөөлөхийн тулд санаатайгаар бүтээгдэж, түгээгдсэн худал хуурмаг мэдээлэл юм.

Ийм өргөн орон зайн дунд оршин буй хуурамч мэдээг тодорхойлохыг олон судлаач эрэлхийлдэг. Тэдний

зарим нь юу мэдээг хуурамч болгодог вэ хэмээн асуугаад үүндээ хариулахын тулд жинхэнэ мэдээ хэрхэн тодорхойлогддогийг авч үзжээ. Мэдээ нь үнэн бодитой байх, баримттай байх гэсэн шаардлагатай нэн тэргүүнд холбогддог<sup>6</sup> тул хуурамч мэдээ хэмээх нэр томъёог оксюморон гэж үзэх ч боломжтой аж. Оксюморон гэдэг нь байж боломгүй гэсэн утга санааг илтгэж байна. Жишээ нь залуу өвгөн, халуун цас гэх мэт. Тэгэхээр мэдээ өөрөө хуурамч байх ёсгүй учраас хуурамч мэдээ нь нэр томъёоны хувьд оксюморон хэдий ч хуурамч хэмээх үг нь үргэлж дуураймал, зохиомол, дүр үзүүлсэн, жинхэнэ бус гэсэн утга санааг илтгэнэ<sup>7</sup>.

**Б**үтээгдэхүүн, үйлчилгээний талаар бичигдсэн хуурамч сэтгэгдлийн тухай судалгаанд хуурамч хэмээх үгийн мөн чанарыг зорилготой холбон авч үзсэн бөгөөд хуурамч сэтгэгдэл (review) гэдгийг худалдан авагчдын сонголтод нөлөөлөхийн тулд тэднийг төөрөгдүүлэх зорилготой үйлдэл хэмээн тодорхойлжээ<sup>8</sup>.

Хуурамч мэдээ нь сэтгүүл зүй, олон нийтийн харилцаанд эртнээс оршин байсны хувьд түүнийг тодорхойлсон олон зуун судалгаа бий. Тиймээс хуурамч мэдээ хэмээх ойлголтыг өргөн утгаар авч үзэх нь зүйтэй. Ингэснээр юу хүлээн авагчдыг хуурамч мэдээнд итгэхэд хүргэж байна вэ гэдгээс эхлээд хуурамч мэдээ олон нийтийн санаа бодолд хэрхэн нөлөөлж буй зэргийг системтэйгээр судлах боломжтой болно.

## **2. Хуурамч мэдээний ангилал.**

Ташаа мэдээллээс биш мэдээлэл хүртэлх өргөн орон зайд оршин буй хуурамч мэдээг ангилах судалгааг олон судлаачид хийжээ. Тэдгээрээс хамгийн сүүлийн үеийн, өргөн хүрээний судалгаа нь Наньяаний Технологийн Их

Сургуулийн судлаачдынх (Эдсон С, Зен Вэй Лим, Ричард Линг нар) юм. Тэд 2003-2017 оны хооронд хуурамч мэдээний талаар хөндсөн 34 эрдэм шинжилгээний өгүүллийг судалж хуурамч мэдээний ангиллын талаарх ойлголтыг авч үзэж, дараах таван ангиллыг гаргажээ<sup>9</sup>.

#### 1. *News satire- Хошигнол мэдээ*

Элэглэсэн мэдээллийн хөтөлбөр хэмээн тооцогддог энэхүү үйл ажиллагаа нь хуурамч мэдээний хамгийн нийтлэг хэлбэрийн нэг. Ийм хөтөлбөр нь одоо болж буй үйл явдалд анхаардаг бөгөөд телевизийн мэдээний хэв маягийг агуулдаг. Тодорхой үйл явдалд байр сууриа илэрхийлэх, олон нийтийн сэтгэгдлийг хүлээн авах г.м. Мэргэжлийнхнээс гол ялгаатай нь энэ үйл ажиллагааг эрхлэгчид мэдээллээс илүүтэйгээр зугаацуулах гол зорилготой. Нэвтрүүлэгчид нь өөрсдийгөө сэтгүүлч, хөтөлгөч биш комедиан, энтертейнер хэмээн нэрлэдэг. Судлаачид үүнийг хэвлэл мэдээллийн экосистемд нөлөөлдөг том хэсэг гэж үздэг бөгөөд хэлбэрийн хувьд хуурамч гэж тооцдог.

#### 2. *News parody- Дуураймал мэдээ*

Хүлээн авагчдын анхаарлыг татахын тул элэглэж, хошигнодоогоороо хошигнол мэдээтэй төстэй боловч зорилгоо биелүүлэхийн тулд баримтгүй мэдээлэл ашигладагаараа ялгаатай.

#### 3. *News fabrication - Зохиомлоор мэдээ болгох*

Баримтад суурилагагүй боловч “хууль ёсны” төрхөө олохын тулд мэдээний хэлбэрээр бичигдсэн байдаг (мэдээ шиг харагдахыг эрмэлзсэн). Пародигаас ялгаатай нь зохиогч болон хүлээн авагчийн хооронд энэ бол маазрал, буруу, худал хуурмаг гэсэн төсөөлөл огт байдаггүй. Харин ч эсрэгээрээ яг үнэн мэт ойлгогдохыг хичээдэг. Олон нийтийг төөрөгдүүлэх, хэн нэгний нэр хүнд,

эрх ашигт халдах зорилготой ийм төрлийн хуурамч мэдээг мэргэжлийнхэн өлгөж авах нь асуудлыг бүр төвөгтэй болгодог.

#### 4. *Photo manipulation - Фото төөрөгдүүлэлт*

Хуурамч мэдээллийн өөр нэг хэлбэр нь бодит зураг, бичлэгийг хуурамч дүрслэл үүсгэхэд ашиглах явдал юм. Технологийн боломжоос шалтгаалан (фотошоп) фото төөрөгдүүлэлт хийхэд хэцүү биш болсон нь энэ хэлбэрийн хуурамч мэдээний тоог өсгөж байна.

#### 5. *Advertising and PR - Зар сурталчилгаа болон PR*

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин олон нийтэд хүрч буй реклам, олон нийтийн харилцааны зорилготой контентууд хуурамч мэдээллийн төрөлд багтжээ. Хэдийгээр контент мэдээллийн агентлагаар дамжиж байгаа ч агуулга нь төөрөгдүүлсэн, нэг талыг барьсан гэх мэт байдлаар хуурамч байх магадлал өндөр аж. Үүнийг мэдээллийн агентлаг нягтлах болон нэвтрүүлэх эсэхээ шийдэхэд адармаатай байдаг.

### 3. Судалгааны арга.

Фэйсбүүкээр тархсан хуурамч мэдээнүүдийг хоёр сарын хугацаанд буюу 2018 оны гуравдугаар сарын 17-оос тавдугаар сарын 19-ний хооронд цуглуулав. Мэдээлэл цуглуулахад МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимээс арван оюутан сонгогдсон бөгөөд тэд хуурамч мэдээг олж илрүүлэх, хэрхэн олж авах талаар сургалтанд хамрагдсан. Хуурамч мэдээний 200 орчим тохиолдлыг бүртгэж, нарийвчлан шинжилж, хуурамч эсвэл бодит эсэхийг урьдчилан тогтоосон шалгуураар шалгасан болно. Цуглуулсан хуурамч мэдээнүүдийг сэдэв, төрөл, эх сурвалж, тархалт, сэтгэгдэл, ангилал зэргээс нь хамааруулан дүн шинжилгээ хийсэн. Эдгээр

түүхээс гарч болзошгүй үр дагаврыг бид тодорхойлохыг хичээв.

Судалгаанд оролцогчид судалгаа хийх хугацаанд өдөр бүр аль болох олон удаа фэйсбүүк орж, урт скролл хийж хуурамч мэдээг цуглуулна. Дата цуглуулж буй хамтын талбарт олсон мэдээгээ оруулж, холбогдох мэдээллүүдийг нөхнө. Бүгдийг баримтжуулж скрийншот хийх ерөнхий зарчим баримтлав.

Сэдвийн хувьд нийт цуглуулсан 195 хуурамч мэдээг дараах байдлаар кодолж, 11 хуваасан. Ингэхдээ сэдэв давхардуулж тоолоогүй, нэг мэдээг нэг л сэдэвт хамааруулан авч үзэв. Харин аль аль сэдэвт хамаарч болох мэдээг

сэдвийн давхцалаар нь тусад нь тоолохдоо асуудал гол хамаарч буй сэдвийн кодыг эхэнд, хам сэдвийн кодыг хоёрдугаарт авч үзэн тоолов. *Жишээ нь: “Хятадууд гадил жимсэнд ДОХ-ын халдвартай цус шахсан” тухай мэдээг сэдвийн давхцалаар тоолохдоо агуулга, зорилгыг нь харгалзан үзээд Anti-China/Foreigners(8) + Health(1) хэмээн кодолж тоолов.*

Мөн сэдэв дотор дэд сэдэв үүсгэн тоолсон. Тухайлбал Politics/Corruption(9) ангилал дотор хамгийн олон давхцаснаар нь М.Энхболд, Х.Баттулгатай холбоотой гэх мэтээр ангилж үзэв.

Код	Сэдэв	Тайлбар
1.	Эрүүл мэнд	Эрүүл мэнд, гоо сайхан, хүнсний аюулгүй байдал, эм тариатай холбоотой мэдээг авч үзэв.
2.	Гэмт хэрэг, осол	Хүчирхийлэл, хүчингийн хэргээс бусад гэмт хэрэг, ослын талаарх мэдээг авч үзэв.
3.	Цуу яриа	Цуу яриа
4.	Шашин, итгэл үнэмшил	Монголчуудын шашин, уламжлал, нийтлэг итгэл үнэмшилтэй холбоотой мэдээг авч үзэв.
5.	Олны танил хүмүүс	Алдартан, одод, олны танил хүмүүстэй холбоотой мэдээг авч үзэв. Тухайн хүн нь улстөрч бөгөөд мэдээний агуулга нь улстөртэй биш хувь хүний амьдралтай холбоотой бол энэ ангилалд оруулсан.
6.	Фэйсбүүкийн тухай	Фэйсбүүкийн тухай олон хуурамч мэдээтэй таарсан тул тусад нь ангилалд оруулав.
7.	Бизнес, санхүү	Бизнес, санхүүтэй холбоотой мэдээг авч үзэв. Тухайлбал, байрны зээлийн асуудал, уул уурхай г.м.
8.	Гадаадынхныг эсэргүүцсэн	Гадаадынхныг, ялангуяа хятадуудыг үзэн ядсан, тэдний эсрэг турхирсан хуурамч мэдээг авч үзэв.
9.	Улс төр, авлига	Улстөр, улстөрчид, авлига хээл хахуультай холбоотой мэдээг авч үзэв.
10.	Бусад	Олон давтагдаагүй, ганц нэг хөндөгсөн сэдэвт орох мэдээг авч үзэв.
11.	Хүчирхийлэл	УИХ-ын гишүүний холбогдсон хүчирхийллийн хэргийн дараа болон Ерөнхийлөгчийн хүчирхийлэгчийг цаазаар авах хуулийн төсөлтэй холбоотой ийм төрлийн мэдээ олон гарсан тул гэмт хэрэг ангиллаас тусад нь авч үзэв.

**Хэлбэрийн хувьд** нийт цуглуулсан 195 мэдээг холбоос (link), зураг (photo), текст (text), бичлэг (video) гэсэн 4 ангилалд хуваан авч үзэв. Хэлбэрийн хувьд тоолохдоо дараах зарчмыг баримтлав.

- Дээрх дөрвөн хэлбэр нь ийм агуулгатай.
- Холбоос (link)- Мэдээг үргэлжлүүлэн унших вэб холбоостой.
- Зураг (photo)- Зураг хавсаргасан.

- Текст (text)- Дан текстээс бүрдэх агуулга бөгөөд өөр хэлбэр хавсаргагүй.
- Бичлэг (video)- Бичлэг хавсаргасан.
  - Холбоос, зураг, бичлэгийн аль нэгийг хавсаргасан хэрнээ текстэн тайлбартай бол яах вэ? Дан текстэн пост, зурагтай пост гэх мэтээр ялгах уу? Бүх хэлбэрүүдийг ерөнхийд нь пост (post) гэж нэрлэж байгаа учраас видеотой пост, дан пост, зурагтай пост гэх мэтээр нэрлэхээс татгалзав. Мөн зураг, бичлэг, холбоос бүхий пост дийлэнхдээ текстэн тайлбартай хамт байгаа учир холбоос (link), зураг (photo), текст (text), бичлэг (video) хэмээн шууд нэрлэж ангилав.
  - Зураг, текст, бичлэг хэлбэрээр хэрнээ мэдээний дор сэтгэгдэл хэсэгт холбоос оруулж, үргэлжлэлийг холбоосоор дамжуулан хүлээн авах тохиолдолд аль хэлбэрт тоолох вэ? Холбоосоор орж үзээд ажиллаж байвал линкэд тооцоод, ажиллахгүй (кликбэйт) бол холбогдох бусад хэлбэрээр (зураг, текст, бичлэг) тооцоод явсан.
  - Постонд холбоос оруулахаар зураг юмуу видеоны дүрс өөрөө таглагдаж орж ирдэг тул энэ тохиолдолд зураг, видеоны аль нэгэнд биш холбоос хэлбэрт оруулан тооцов.
  - Кликбэйт тохиолдолд хуурамч мэдээнд тооцох уу? Тусад нь кликбэйт гэсэн хэлбэрт авч үзэх үү? Хүлээн авагчийг төөрөгдүүлж байгаа учраас хуурамч мэдээнд тооцно. Гэхдээ тусад нь хэлбэрт авч үзэхгүй бөгөөд таглагдан/хавсрагдан орсон хэлбэрээр нь авч үзнэ. Учир нь хүлээн

авагчид клик хийхгүйгээр тухайн мэдээний тайлбарт шууд итгэж, төөрөгдөж, хариу үйлдэл үзүүлж байгаа учраас.

**Э**х сурвалжийн хувьд дараах 5 ангиллаар авч үзэв. Эх сурвалж гэдэг нь судлаачийн фэйсбүүк нь юсфийд дээр хуурамч мэдээг түгээж харагдаж буй бүх субъект юм. Хуурамч мэдээг түгээж буй эх сурвалжуудыг өргөн хүрээнд тогтоохын тулд тухайн сэдвээр фэйсбүүк дээрээ хайлт хийгээд ижил мэдээг түгээсэн бүх эх сурвалжуудыг скрийншот хийж авсан.

Эх сурвалжуудыг тоолохдоо судалгааны багийнхны бүх скрийншотод орсон эх сурвалжуудыг давтагдсан тоогоор тоолов. Учир нь дийлэнх эх сурвалжууд хуурамч санаатайгаар дахин дахин түгээж байв. Жишээ нь: *“Дуучин С.Жавхлан Т.Баясгаланг оршуулах ёслолд оролцжээ” гэсэн мэдээ хуурамч вэб дээр тавигдаад түүнийг хуурамч аккаунт групп рүү түгээсэн бол вэбсайт, хуурамч аккаунт, групп гэсэн эх сурвалжууд дээр давхар тоологдоно гэсэн үг.*

Үүнд:

1. Account (real)- Хуурамч мэдээг түгээж буй аккаунт хаяг бодит хүнийх. Бодит хүн нь сэтгүүлч эсэхийг нягтлав.
2. Account (fake)- Хуурамч мэдээг түгээж буй аккаунт хаяг бодит хүнийх биш, хуурамч.
3. Page- Хуурамч мэдээг түгээж буй хуудас. Хуудас нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хуудас эсэхийг нягтлав.
4. Group- Хуурамч мэдээг түгээж буй групп. Групп рүү бодит/хуурамч аккаунтын аль нь түгээсэн болохыг мөн нягталж тоолов.
5. Website- Хуурамч мэдээ түгээж буй вэб хаяг. Энэ нь олон нийтийн

хэвлэл мэдээлийн хэрэгсэлд тавигдах шаардлага хангах эсэхийг нягтлав.

6. Private message- Хуурамч мэдээг түгээж буй эх сурвалж нь хувийн чат. Бодит/хуурамч аккаунтын аль нь түгээсэн болохыг мөн нягталж тоолов.

**Түгээлт буюу хүлээн авсан байдлын хувьд** дараах байдлаар ангилав.

1. Likes & Emotions- Хуурамч мэдээнд лайк дарж, сэтгэл хөдлөл үзүүлсэн тоо.
2. Shares- Хуурамч мэдээг түгээсэн тоо.
3. Comments- Хуурамч мэдээнд хариулсан сэтгэгдлийн тоо.
4. Views- Хуурамч мэдээ нь бичлэг хэлбэртэй тохиолдолд түүнийг үзсэн тоо.

Судалгааны ажлын зарчмын дагуу хуурамч мэдээ олсон тохиолдолд түүний түлхүүр үгээр хайлт хийж тус мэдээ өөр ямар ямар эх сурвалжуудаар хаана хаана түгээгдсэнийг бүртгэж, эх сурвалжаар ангилж, бүгдийг скрийншот хийж авсан. Тухайн мэдээг хүлээн авсан байдлыг тооцохдоо холбогдох скрийншотууд тус бүр дээрх лайк, эмоушн, шэйр, коммент, үзэлтийн тоог холбогдох ангиллаар нэмж тоолов.

Хүлээн авсан байдлын үзүүлэлт нь дата цуглуулагч хуурамч мэдээ түгсэнээс хойш хэр удаан хугацааны дараа түүнтэй таарснаас хамаарч буйг анхаарна уу. Хуурамч мэдээ дөнгөж түгсэний дараа олсон бол энэ үзүүлэлт бага байх магадлал өндөр.

**Ангиллын хувьд** нийт 195 мэдээг С.Эдсон нарын ангиллаар авч үзэв.

**Хуурамч мэдээний шинж чанарын хувьд** хуурамч мэдээнүүдэд

нийтлэг ажиглагдаж буй шинж чанарууд, зүй тогтлыг тодорхойлохдоо хамгийн олон хүнд хүрсэн 10 мэдээний бүтэц, хэл найруулга, хэлбэр, шинж байдал, зорилго зэргэд үндэслэв. **Зорилгын хувьд** ямар зорилгоор хуурамч мэдээг түгээж буйг тодорхойлохдоо дата цуглуулагчид дараах 4 категорид ангилсан.

1. Хувь хүн, аж ахуй нэгж, бүлгийн эрх ашигт халдах, гутаан доромжлох, нэр төрд халдах зорилготой
2. Сувгийн нөлөөг тэлэх зорилготой- Групп, хуудас, хандалтын нөлөөг тэлэх боломжтой, сенсаацласан өнгө аястай, хэний ч эрх ашгийг хөндөөгүй хуурамч мэдээ.
3. Санхүүгийн зорилготой (кликбэйт)- Холбоосоор дарж ороход ажиллахгүй эсвэл реклам уншигдсан тохиолдолд.
4. Олон нийтийг төөрөгдүүлэх замаар тэдний санаа бодолд нөлөөлөх зорилготой-Монголын нийгэмд болсон үйл явдалтай холбогдож буй, олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд нөлөөлөхүйц хуурамч мэдээ.

#### 4. Судалгааны үр дүн

Код	Сэдэв	Хувь
1.	Эрүүл мэнд	23ш (12%)
2.	Гэмт хэрэг, осол	18ш (9%)
3.	Цуу яриа	7ш (3%)
4.	Шашин, итгэл үнэмшил	6ш (3%)
5.	Олны танил хүмүүс	47ш (24%)
6.	Фэйсбүүкийн тухай	9ш (4%)
7.	Бизнес, санхүү	9ш (4%)
8.	Гадаадынхныг эсэргүүцсэн	25ш (13%)
9.	Улс төр, авлига	19ш (10%)
10.	Бусад	13ш (7%)
11.	Хүчирхийлэл	19ш (10%)
		<b>Нийт-195</b>

Нийт цуглуулсан 195 мэдээг сэдвээр нь ангилвал олны танил, нэр алдартай хүмүүстэй холбоотой хуурамч мэдээ хамгийн их (24%) байна. Ялангуяа урлагийнхны хувийн амьдралтай холбоотой хуурамч мэдээнүүд олон байсныг онцолмоор байна. Жишээ нь: Дуучин Болд, Чулуунчимэг нарын салалтын тухай, дуучин Дэлгэрмөрөнгийн эхнэрийн үхлийн тухай, дуучин Амина өвөрмонгол хүнтэй гэрлэх тухай, жүжигчин Адъяа эхнэрээ зодсон гэхтэй холбоотой мэдээнүүд олон байв. Үүний дараа гадаадынхныг үзсэн ядсан агуулга бүхий мэдээ 13%-ийг эзэлжээ. Энэ сэдэвт 25 мэдээ

багтсанаас дийлэнх нь буюу 20 нь хятадуудыг үзэн ядсан мэдээнүүд байв. Үлдсэн нь вьетнам, турк, солонгосчуудыг буруутгасан мэдээнүүд байв.

**Сэдвийн давхцалаар** авч үзвэл олны танил хүмүүсийн талаарх цуу яриа бүхий хуурамч мэдээ хамгийн олон байна. Мөн эндээс хятадуудыг үзэн ядсан мэдээнүүд дийлэнхдээ олны танил хүмүүс, хүчирхийлэл, эрүүл мэндийн асуудалтай холбогдож буйг харж болно. Нийт сэдвийн 12%-ийг эзэлж буй эрүүл мэндтэй холбоотой хуурамч мэдээ нь монголчуудын итгэл үнэмшил, шашин шүтлэгтэй холбогдож буйг харж болно.

Сэдэв (код)	Хуурамч мэдээний тоо	Дэд сэдэв
Эрүүл мэнд (1)	23ш (12%)	Хүнсний аюулгүй байдал-12ш, Гоо сайхан-3ш, Ерөнхий эрүүл мэнд-4ш, Эм эмчилгээ-2
Бизнес, санхүү (7)	9ш (4%)	1072 хувьцаа тараах- 4, Зээл тэглэх- 2
Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	25ш (13%)	Хятад-20, Вьетнам-3
Улстөр, авлига (9)	19ш (10%)	М.Энхболд-6, Х.Баттулга-3, С.Батболд, З.Энхболд, Г.Уянга, Н.Номтойбаяр, П.Очирбат, А.Сүхбат

Дэд сэдвээр авч үзвэл эрүүл мэндтэй холбоотой хуурамч мэдээнүүдийн хагас нь хүнсний эрүүл ахуйтай, харин бизнес, санхүүтэй холбоотой мэдээнүүдийн хагас нь 1072 хувьцааг тарааж эхлэхтэй холбогджээ. Улстөрчидтэй хамааралтай хуурамч мэдээнүүдийн дийлэнх нь УИХ-ын дарга асан М.Энхболд, Ерөнхийлөгч Х.Баттулга нартай хамааралтай байна.

Хэлбэрийн хувьд холбоос бүхий мэдээ дийлэнх хувийг эзэлж байна. Линк, фото хэлбэртэй хуурамч мэдээ нь итгүүлэх байдлыг нэмэгдүүлж байв. Харин видео мэдээ цөөн байгаа нь сайн хэрэг бөгөөд хуурамч мэдээ үйлдвэрлэгчид видеог эвлүүлж, монтажлах “өндөр” түвшинд очоогүй байгааг харуулна.

Хэлбэр (код)	Хуурамч мэдээний тоо
Холбоос (1)	127ш (65%)
Зураг (2)	51ш (26%)
Текст (3)	12ш (6%)
Видео (4)	5ш (3%)
	<b>Нийт-195 (100%)</b>

Эх сурвалж (код)	Хуурамч мэдээний тоо
Аккаунт (жинхэнэ)	172
Аккаунт (хуурамч)	270
Хуудас	221
Групп	200
Вэбсайт	207
Чат	6
	<b>Нийт-1076</b>

**Х**уурамч мэдээ түгээсэн жинхэнэ аккаунт олноос гадна хуурамч аккаунтын тооноос хол зөрүүгүй байгаа нь харамсалтай. Учир нь энэ нь нэг талаас хуурамч мэдээнд тэдгээр хүмүүс итгэж байгааг, нөгөө талаас тэдний хэвлэл мэдээллийн боловсролын түвшин муу байгааг харуулж байна. Хуурамч мэдээг түгээж буй бодит хүмүүс дунд мэргэжлийн гурван сэтгүүлч байсан нь дутагдалтай.

Давхардсан тоогоор 300 орчим хуурамч аккаунт хуурамч мэдээ түгээж байгаагийн дотор цөөнгүй нь тогтмол хэд хэдэн групп рүү түгээдэг, тэдгээр

группуудын модератор эсвэл админ байсан нь анхаарал татсан. Өөрөөр хэлбэл тэд хуурамч мэдээгээр группээ амьдруулдаг, тэжээдэг, тэнд гишүүнчлэлтэй хэрэглэгчдийн санаа бодолд тогтмол, зориудаар нөлөөлж байна. *Жишээ нь: Eegii Valueble Amelia, Дариа Дарьхан, НямОд Эгшиглэн зэрэг хуурамч аккаунт нь Монголоо Mongoloo группийн модераторууд бөгөөд хуурамч мэдээнүүдийг үүнээс гадна өөрсдийн хөтөлдөг бусад холбогдох группууд рүү тогтмол түгээж байна.* Ингэж ажилладаг хуурамч аккаунтууд олон бий.

	<b>Хамгийн олон удаа хуурамч мэдээ түгээгдсэн 10 групп</b>	<b>Хуурамч мэдээ түгээгдсэн нийт тоо</b>
1	Mongoloo Монголоо	46
2	Jirgee medee Жиргээ мэдээ	17
3	Barterdii Huuhnuudee	15
4	Нийслэл зар Niislel zar	14
5	Гар утасны наймаа	13
6	Олуулаа	9
7	PRIUS эзэмшигчдийн нэгдсэн групп	6
8	Мэдэхгүй зүйлээ асуу	6
9	Huuchin tabilga ger ahuin tsahilgaan baraa	5
10	Гар утасны хар зах	5
	<b>Хамгийн олон удаа хуурамч мэдээ түгээгдсэн 10 хуудас</b>	<b>Хуурамч мэдээ түгээгдсэн нийт тоо</b>
1	Зугаатай Залуус	8
2	Life is hot	5
3	Онц сонирхолтой онлайн дэлгүүр	5
4	Az kino	4
5	Аз жаргалтай хот Happy city	4
6	Сенсац мэдээ	4
7	Гоомарал Сонин сайхан юу байна	4
8	Зөвлөгөө	3
9	Онлайн видео мэдээ	3
10	Охид бүсгүйчүүдийн зөвлөгөө	3

Давхардаагүй тоогоор 59 групп, 138 хуудсаар дамжуулан хуурамч мэдээг түгээжээ. Давхардсан тоогоор хуудас, группээр нийтдээ 421 удаа хуурамч мэдээ түгээгдсэн байна. Хамгийн олон

удаа хуурамч мэдээ түгээгдсэн дээрх группуудыг хуурамч аккаунтууд ажиллуулж байна. Группт түгээгдсэн хуурамч мэдээний тоо хуудсанд түгээгдсэнээс харьцангуй өнпөр байгаа нь хуудас



хуурамч мэдээгээр дагагчийн тоог нэмэгдүүлэх зорилго дийлэнхдээ агуулж байсан бол группт олон нийтийн санаа бодолд тогтмол нөлөөлөх, тэдний сонголтыг өөрчлөх зорилго агуулж буйтай холбоотой гэж үзсэн.

Д/д	Вэбсайт	Давтамж
1	<a href="http://www.bestofadvice.com">www.bestofadvice.com</a>	18
2	<a href="http://www.khoshinshog.com">www.khoshinshog.com</a>	16
3	<a href="http://www.bestnews100.com">www.bestnews100.com</a>	13
4	<a href="http://www.anguush.info">www.anguush.info</a>	6
5	<a href="http://www.iirge.com">www.iirge.com</a>	6
6	<a href="http://www.foxnews.mn">www.foxnews.mn</a>	5
7	<a href="http://www.lifeishot.blog">www.lifeishot.blog</a>	5
8	<a href="http://www.lifeishot.club">www.lifeishot.club</a>	5
9	<a href="http://www.niisleliimedee.com">www.niisleliimedee.com</a>	5
10	<a href="http://www.shinemedee.net">www.shinemedee.net</a>	5
11	<a href="http://www.sodonmedee.com">www.sodonmedee.com</a>	5
12	<a href="http://www.amjilt.news">www.amjilt.news</a>	4
13	<a href="http://www.caakfun.mn">www.caakfun.mn</a>	4
14	<a href="http://www.ehleh.com">www.ehleh.com</a>	4
15	<a href="http://www.sonirholtoi.com">www.sonirholtoi.com</a>	4
16	<a href="http://www.todmedee.com">www.todmedee.com</a>	4
17	<a href="http://www.caak.mn">www.caak.mn</a>	3
18	<a href="http://www.ibook.mn">www.ibook.mn</a>	3
19	<a href="http://www.medeemgl.com">www.medeemgl.com</a>	3
20	<a href="http://www.mongol-media.com">www.mongol-media.com</a>	3

Давхардаагүй тоогоор 92 вэбсайтаар нийт 207 удаа хуурамч мэдээ түгээжээ. Сайтуудын дийлэнх нь блог маягийн, мэргэжлийн бус дүр эсгэсэн сайтууд байв. Кликбэйт сайтууд байсныг дурдах

хэрэгтэй. Хуурамч мэдээг түгээсэн сайтын дотор medee.mn, ubinfo.mn, zapost.mn, reak.mn зэрэг олонд танигдсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гарсан нь харамсалтай. Мөн олонд танил болсон, тогтмол хандалт-тай хэрнээ мэргэжлийн ангилалд оруулж болохооргүй saak.mn, xogom.mn гэх мэт хэд хэдэн завсрын сайтууд хуурамч мэдээг түгээж байна.

Хувийн чатаар түгээсэн хуурамч мэдээ нь Марк Зукерберг фэйсбүүкийг төлбөртэй болгох тухай бөгөөд жинхэнэ хаягуудаас ирсэн байв.

Харилцан үйлчлэлцэл	Нийт-221992
Хуваалцсан тоо (Number of sharing)	125466
Лайкын тоо (Number of likes)	52175
Сэтгэгдлийн тоо (Number of comments)	29208
Үзэлт (Number of views)	15143

Түгээлт буюу хүлээн авсан байдлыг хувьд хуурамч мэдээг хуваалцсан тохиолдол хамгийн өндөр байна. Харин үзэлтийн тоо бага байгаа нь видео хэлбэрийн хуурамч мэдээ цөөн байсантай холбоотой.

Дээрх хүснэгтүүдээс нийт 195 хуурамч мэдээг 1076 эх сурвалж 125500 орчим удаа шэйрлэж хамгийн багадаа 222 мянган хүнд хүрснийг харж болно.

Хамгийн олон түгээгдсэн 10 хуурамч мэдээ			
№	Гарчиг, тайлбар	Сэдэв (код)	Түгээлтийн тоо
1	Шар будаагаар бөөрөө эмчлэх -Бөөрний өвчнүүдийг анагаадаг тухай	Эрүүл мэнд (1)	34037
2	Кола их уудаг хүний бөөрөнд ийм их чулуу байдаг гэнэ	Эрүүл мэнд (1)	19200
3	Багануурт 10 мянган хятад суурьшуулах гэж байна	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	8798

4	Саяхан болсон гунигтай түүх - Ээж нь хүүхдээ зодож хөнөөсөн тухай	Хүчин, хүчирхийлэл (11)	8282
5	Миний нэг дүү Хятадын ногоо тариалалтын талбайд ажиллаж ирээд ингэж хуучлав - Хятадаас оруулж ирдэг ногоог хортой усаар усалдаг тухай	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	7612
6	Гадаадын олон нийтийн сүлжээгээр ийм мэдээ явж байна - Хүмүүс гэртээ хүүхэд, амьтанд хортой цэцэг тарьдаг тухай	Эрүүл мэнд (1)	5928
7	Ёстой хөгийн новшнууд шүү- Хятад, Солонгос хоолны газруудын үйлчлэгчдийн муу санаа, бузар үйлдлүүд г.м	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	5579
8	Монголын одоогийн сүлдний билэгдэл хятадаас гаралтай- Амьгүй хятад сүлднээс татгалзая	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	5500
9	Нярай хүүхдийн ойролцоо автобус сигналдсанаас цус харважээ	Цуу яриа (3)	4097
10	Яг одоо шивээс хийлгэх гэж байгаа бол газраа судлаарай- Шивээс эрүүл мэндэд хортой тухай	Эрүүл мэнд (1)	3014
<b>Хамгийн олон лайк, эмоушн цуглуулсан 10 хуурамч мэдээ</b>			
<b>№</b>	<b>Гарчиг, тайлбар</b>	<b>Сэдэв (код)</b>	<b>Лайк&amp;Эмоушн тоо</b>
1	Миний нэг дүү Хятадын ногоо тариалалтын талбайд ажиллаж ирээд ингэж хуучлав - Хятадаас оруулж ирдэг ногоог хортой усаар усалдаг тухай	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	2600
2	Кола их уудаг хүний бөөрөнд ийм их чулуу байдаг гэнэ	Эрүүл мэнд (1)	1400
3	Оюунчимэг: Гишүүн Гантулга нь хүчиндсэн биш хүчиндүүлсэн байх магадлалтай	Улстөр, авлига (9)	1350
4	АТГ-ын дарга болох хүмүүс	Улстөр, авлига (9)	1300
5	Дуучин Дэлгэрмөрөн нууцаар хуримаа хийжээ	Олны танил хүмүүс (5)	1200
6	Шар будаагаар бөөрөө эмчлэх -Бөөрний өвчнүүдийг анагаадаг тухай	Эрүүл мэнд (1)	1000
7	Ёстой хөгийн новшнууд шүү- Хятад, Солонгос хоолны газруудын үйлчлэгчдийн муу санаа, бузар үйлдлүүд г.м	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	985
8	Очирбат хужаа Тамсагийн ордоос их хэмжээний мөнгө идсэнээс хамар нь ийм болсон	Улстөр, авлига (9)	793
9	Хэрэв таны FB хамгаалалттай бол ногоон бичигдэнэ, хэрэв хар байвал хаяг, нууц үгээ солиорой	Фэйсбүүкийн тухай (6)	766
10	Гадаадын олон нийтийн сүлжээгээр ийм мэдээ явж байна - Хүмүүс гэртээ хүүхэд, амьтанд хортой цэцэг тарьдаг тухай	Эрүүл мэнд (1)	762

<b>Хамгийн олон сэтгэгдэл авсан 10 хуурамч мэдээ</b>			
<b>№</b>	<b>Гарчиг, тайлбар</b>	<b>Сэдэв (код)</b>	<b>Сэтгэгдлийн тоо</b>
1	Түрээсийн байрны үнээр орон сууцтай болох төсөл	Бизнес, санхүү (7)	4600
2	BFF код бичээд нууцлалаа шалгаарай, Фэйсбүүк төлбөртэй болно	Фэйсбүүкийн тухай (6)	2500
3	Кола их уудаг хүний бөөрөнд ийм их чулуу байдаг гэнэ	Эрүүл мэнд (1)	2300
4	Хэрэв таны FB хамгаалалттай бол ногоон бичигдэнэ, хэрэв хар байвал хаяг, нууц үгээ солиорой	Фэйсбүүкийн тухай (6)	2100
5	Багануурт 10 мянган хятад суурьшуулах гэж байна	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	1650
6	Монголын одоогийн сүлдний билэгдэл хятадаас гаралтай - Амьгүй хятад сүлднээс татгалзая	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	1500
7	Оюунчимэг: Гишүүн Гантулга нь хүчиндсэн биш хүчиндүүлсэн байх магадлалтай	Улстөр, авлига (9)	1464
8	Миний нэг дүү Хятадын ногоо тариалалтын талбайд ажиллаж ирээд ингэж хуучлав - Хятадаас оруулж ирдэг ногоог хортой усаар усалдаг тухай	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	1200
9	Нэрний эхний гурван үсгийг бичээд ард нь .com тавь үнэхээр гайхалтай зүйл харах болно	Фэйсбүүкийн тухай (6)	1200
10	BFF код бичээд нууцлалаа шалгаарай	Фэйсбүүкийн тухай (6)	1200
<b>Хамгийн их харилцан үйлчлэлцсэн 10 хуурамч мэдээ (most engaged)</b>			
<b>№</b>	<b>Гарчиг, тайлбар</b>	<b>Сэдэв (код)</b>	<b>Number of engagement (like+share+comment)</b>
1	Шар будаагаар бөөрөө эмчлэх -Бөөрний өвчнүүдийг анагаадаг тухай	Эрүүл мэнд (1)	35520
2	Кола их уудаг хүний бөөрөнд ийм их чулуу байдаг гэнэ	Эрүүл мэнд (1)	22900
3	Саяхан болсон гунигтай түүх - Ээж нь хүүхдээ зодож хөнөөсөн тухай	Хүчирхийлэл (11)	15904
4	Сар бүр 500 мянган төгрөг төлөөд хямд байртай болоорой	Бизнес, санхүү (7)	15000
5	Багануурт 10 мянган хятад суурьшуулах гэж байна	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	13440
6	Монголын одоогийн сүлдний билэгдэл хятадаас гаралтай- Амьгүй хятад сүлднээс татгалзая	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	12900

7	Миний нэг дүү Хятадын ногоо тариалалтын талбайд ажиллаж ирээд ингэж хуучлав - Хятадаас оруулж ирдэг ногоог хортой усаар усалдаг тухай	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	11412
8	Түрээсийн байрны үнээр орон сууцтай болох төсөл	Бизнес, санхүү (7)	7500
9	Ёстой хөгийн новшнууд шүү- Хятад, Солонгос хоолны газруудын үйлчлэгчдийн муу санаа, бузар үйлдлүүд г.м	Гадаадынхныг эсэргүүцсэн (8)	7482
10	Гадаадын олон нийтийн сүлжээгээр ийм мэдээ явж байна - Хүмүүс гэртээ хүүхэд, амьтанд хортой цэцэг тарьдаг тухай	Эрүүл мэнд (1)	7401

Хамгийн олон удаа хүнд хүрсэн 10 хуурамч мэдээний хагас нь Хятад/гадаадынхныг эсэргүүцсэн, гурав нь эрүүл мэнд, үлдсэн нь бизнес, санхүү болон хүчирхийлэлтэй холбоотой мэдээ байв. Хамгийн олон удаа хүнд хүрсэн 10 хуурамч мэдээний нийтлэг шинжийг мэдээг хүлээн аваад итгэсэн тохиолдолд төрөх сэтгэгдэл болон доорх скрийншотууд дээр үндэслэн тодорхойлов.

- Ямар ч баримт нотолгоо, эх сурвалжгүй.
- Сэтгэл хөдлөлд хүчтэй нөлөөлөх шидтэй. Хүлээн авагчид баярламаар, аймаар, жигшмээр, үзэн ядмаар сэтгэл хөдлөлүүд бий болгож байна.

- Нэг нь линк, бусад нь зурган хэлбэртэй. Өөрөөр хэлбэл хэлбэрийн хувьд итгүүлэн үнэмшүүлэх чадвар өндөр, жинхэнэ мэт дүр эсгэсэн.
- Гарчиг, тайлбарууд нь найруулга зүйн алдаатай.
- Өдөөн хатгасан шинжтэй. Цааш түгээ, дамжуул гэх мэтээр уриалсан.
- Монголчуудын нийгмийн тогтсон ойлголт дээр тогтосон.
- Олон нийтийг төөрөгдүүлэх, сувгийн нөлөөг тэлэх зорилготой.
- Зарим нь тухайн үед нийгэм, улс төрд болсон үйл явдалтай холбоотой.

Хуурамч мэдээг С.Эдсон нарын ангиллаар авч үзэв.		
Код	Ангилал	Хуурамч мэдээний тоо
1	News Satire- Хошигнол мэдээ	0
2	News parody- Дуураймал мэдээ	0
3	News fabrication- Зохиомлоор мэдээ болгох	165 (85%)
4	Photo manipulation- Фото/Видео төөрөгдүүлэлт	25 (13%)
5	Advertising & PR- Зар сурталчилгаа, ПиАр	5 (2%)
		<b>Нийт- 195 (100%)</b>

С.Эдсон нарын ангиллаар хуурамч мэдээг авч үзвэл зохиомлоор үйлдвэрлэж, бий болгосон хуурамч мэдээ

дийлэнх хувийг эзэлж байна. Хошигнол мэдээ, дуураймал мэдээ огт байхгүй бөгөөд зар сурталчилгааны зорилгоор

бий болгосон хуурамч мэдээ цөөн тоогоор байв. Хуурамч мэдээнд фото/видео төөрөгдүүлэлт ашигласан тохиолдол хэд хэд гарчээ.

Зорилгын хувьд олны танил хүмүүсийн нэр төрд халдах, хувийн амьдралыг дэлгэн доромжлох зорилготой хуурамч мэдээ хамгийн олон буюу 44%-ийг эзэлж байна. Үүний дараа олон нийтийг төөрөгдүүлэх замаар тэдний санаа бодолд нөлөөлөх зорилготой мэдээ 29%-ийг эзэлжээ. Ийм зорилготой хэмээн тодорхойлсон мэдээний дийлэнх нь хятадуудыг үзэн ядуулах (Ерөнхийлөгчийн Монгол ялна, Хятадын эрлийзүүдийг улстөрөөс хөөх уриа/бодлого), хүчингийн хэргүүд (МАН-ын залуу гишүүд хүчингийн хэрэгт холбогдсон болон Ерөнхийлөгчийн цаазын ялыг сэргээх тухай хуулийн төсөл) болон улс төрийн шийдвэртэй, улстөрчтэй (УИХ-ын дарга М.Энхболдыг огцруулах г.м) холбоотой байв. Өөрөөр хэлбэл тухайн үед нийгэмд болсон үйл явдалтай холбоотой хуурамч мэдээнүүд байв.

## 5. Дүгнэлт

- Хуурамч мэдээг судлаачид түүнийг өргөн хүрээнд тодорхойлж, үүний хэрээр олон ангилалд хувааж байна. **Тиймээс хуурамч мэдээг өргөн утгаар нь авч үзэх шаардлагатай.**
- Хоёр сар гаруй хугацаанд нийт 195 хуурамч мэдээг 1076 эх сурвалж 125500 орчим удаа шэйрлэж хамгийн багадаа 222 мянган хүнд хүргэжээ.** Энэ бол Монголын цөөн хүн амтай нийгмийн хувьд томдсон тоо буюу аюултай нөхцөл байдал бий болсныг харуулж байна.
- Хуурамч мэдээ нь дараах шинж чанартай байна.** Ямар ч баримт нотолгоо, эх сурвалжгүй хэрнээ жинхэнэ мэт дүр эсгэсэн. Сэтгэл

хөдлөлд хүчтэй нөлөөлсөн, шуурхай мэдээ, цааш түгээ, дамжуул гэх мэтээр өдөөн хатгасан шинжтэй. Гарчиг, тайлбарууд нь найруулга зүйн алдаатай. Монголчуудын нийгмийн тогтсон ойлголт дээр тоглосон. Олон нийтийг төөрөгдүүлэх, сувгийн нөлөөг тэлэх зорилготой, тухайн үед нийгэм, улс төрд болсон үйл явдалтай холбоотой.

- Ангиллын хувьд дийлэнх хуурамч мэдээ нь зохиомол буюу санаатайгаар үйлдвэрлэсэн хуурамч мэдээ байна. Энэ болон бусад дата анализууд нь (хуурамч мэдээ түгээдэг 100 орчим вэбсайт бий болсон г.м) **Монголын нийгэмд хуурамч мэдээг бүтээх, түгээх үйл явц тасралтгүй үргэлжилж байгаа бөгөөд үүнийг тогтмол хийдэг баг, бүлэг үүссэнийг нотолж байна.** Хуурамч мэдээгээр хуудас, группээ тогтмол арчилж дагагчид, гишүүдийнхээ санаа бодолд зориудаар нөлөөлж байгаа тохиолдол цөөнгүй байгаа нь аюултай.
- Сэдвийн хувьд зарим сэдэв нь хэт ерөнхий (эрүүл мэнд), зарим нь хэт нарийвчилсан (хятадуудыг эсэргүүцсэн) байгааг ажиглаж болно. **Хуурамч мэдээний сэдэв нарийвчилсан байна гэдэг нь тухайн сэдэвтэй холбоотой мэдээг санаатайгаар, чухам зорилготойгоор үйлдвэрлэж, түгээж буйг илтгэнэ.**
- Хэлбэрийн хувьд холбоос бүхий хуурамч мэдээ дийлэнх хувийг эзэлж байна. **Энэ нь хуурамч мэдээг жинхэнэ мэт (вэбсайтын мэдээ мэт) харагдуулах зорилготойг харуулж байна.** Учир нь хуурамч мэдээ тавигдсан вэб сайтууд бараг бүгдээрээ блог шинтжэй, сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй сайтууд байсан. Харин видео

мэдээ цөөн байгаа нь хуурамч мэдээ үйлдвэрлэгчид видеог эвлүүлж, монтажлах “өндөр” түвшинд очоогүй байгааг харуулна.

—Хуурамч мэдээ түгээсэн жинхэнэ аккаунт олноос гадна хуурамч аккаунтын тооноос хол зөрүүгүй байна. **Энэ нь хуурамч мэдээнд хүмүүс итгэж, хариу үйлдэл үзүүлж байгааг бодитоор баталж байна.** Хуурамч мэдээ богино хугацаанд асар олон хүнд хүрч буй нь фэйсбүүк хэрэглэгчдийн шүүмжлэлт сэтгэлгээ болон боловсролын түвшин муу байгааг харуулж байна. Тиймээс хуурамч мэдээг ялган таних тухай мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдэнд хэвлэл мэдээллийн боловсрол олгох шаардлагатай. Мөн монголчуудын мэдээлэл хүлээн авч буй зуршлыг судлах шаардлагатай.

—Хуурамч мэдээг түгээж буй эх сурвалжууд дунд мэргэжлийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөн тоогоор байсан нь **сэтгүүлчид нийтэлж, нэвтрүүлж буй бүх контентыг наад захын алхмуудаар баталгаажуулахгүй байгааг, социал медиа дахь контентыг хуулбарлан ашиглаж байгааг харуулж байна.**

—**Олон нийтийг төөрөгдүүлэх зорилготой хуурамч мэдээнүүд дийлэнхдээ улс төрийн асуудалтай холбогдож байна.**

—Цаашид судалгааг үргэлжлүүлэхдээ фэйсбүүк хэрэглэгчдийн сэтгэгдэлд анализ хийх, кэйс судалгаа хийх замаар хуурамч мэдээний үр нөлөөг тодорхойлох, хоорондоо холбоо хамаарал бүхий эх сурвалжуудыг бүлэглэх гэх мэтээр хуурамч мэдээг үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг хэн хэрхэн зохион байгуулж буйд анхаарвал үр дүнтэй. Мөн

алгоритмын шүүлтүүрт өртөхгүйгээр илүү өргөн хүрээнд дата цуглуулахад анхаарах шаардлагатай байна.

### Ишлэл

- <sup>1</sup><https://en.oxforddictionaries.com/definition/post-truth>
- <sup>2</sup> Edson C. Tandoc Jr., Zheng Wei Lim & Richard Ling (2018) Defining “Fake News”, *Digital Journalism*, 6:2, 137-153, DOI: 10.1080/21670811.2017.1360143
- <sup>3</sup> Wardle, Claire. 2017. “Fake News.” It’s Complicated. <https://medium.com/1st-draft/fake-newsits-complicated-d0f773766c79>
- <sup>4</sup><https://www.merriam-webster.com/dictionary/misinformation>
- <sup>5</sup><https://www.merriam-webster.com/dictionary/disinformation>
- <sup>6</sup> Kershner, James W. 2005. *The Elements of News Writing*. Boston, MA: Pearson Allyn and Bacon.
- <sup>7</sup> Andrea, Mecacci. 2016. “Aesthetics of Fake. An Overview.” *Aisthesis* 9 (2): 59.
- <sup>8</sup> Zhang, Dongsong, Lina Zhou, Juan Luo Kehoe, and Isil Yakut Kilic. 2016. “What Online Reviewer Behaviors Really Matter? Effects of Verbal and Nonverbal Behaviors on Detection of Fake Online Reviews.” *Journal of Management Information Systems* 33 (2): 456–481. doi:10.1080/07421222.2016.1205907.
- <sup>9</sup> Edson C. Tandoc Jr., Zheng Wei Lim & Richard Ling (2018) Defining “Fake News”, *Digital Journalism*, 6:2, 137-153, DOI: 10.1080/21670811.2017.1360143

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Edson C. Tandoc Jr., Zheng Wei Lim & Richard Ling (2018) Defining “Fake News”, *Digital Journalism*, DOI: 10.1080/21670811.2017.1360143
2. Kershner, James W. 2005. *The Elements of News Writing*. Boston, MA: Pearson Allyn and Bacon.
3. Andrea, Mecacci. 2016. “Aesthetics of Fake. An Overview.” *Aisthesis* 9 (2)
4. Zhang, Dongsong, Lina Zhou, Juan Luo Kehoe, and Isil Yakut Kilic. 2016. “What

Online Reviewer Behaviors Really Matter? Effects of Verbal and Nonverbal Behaviors on Detection of Fake Online Reviews.” Journal of Management Information Systems 33 (2)

5. dson C. Tandoc Jr., Zheng Wei Lim & Richard Ling (2018) Defining “Fake News”, Digital Journalism.
6. [www.medium.com](http://www.medium.com)
7. [www.merriam-webster.com](http://www.merriam-webster.com)
8. [www.en.oxforddictionaries.com](http://www.en.oxforddictionaries.com)

### Summary

Mongolia is no exception from global problems of dealing with fake news and misinformation. There is increasing number of fake news stories in Mongolian language spread over social media. The consequences of fake news are huge, from causing chaotic situation to influencing public opinion on important issues, including the election results. However, there is no systematic study

on the nature of fake news distributed in Mongolian language on social media. The present study aimed to explore the nature of fake news stories in Mongolian language spread over Facebook. The instances of fake news stories on Facebook were collected from March 17 to May 19, 2018. Ten students were selected from the Department of Journalism and Mass Communication, National University of Mongolia to be data collectors. They were trained on how to detect fake news and capture them. About 200 instances of fake news stories were captured with screenshots. Each case was analyzed thoroughly and verified whether it is fake or real by the pre-determined criteria. Content analysis was conducted on the collected news stories in terms of their topic, type, source, distribution, and comments. We also attempted to determine the potential consequences of these stories. The preliminary findings of this study will be presented.